



**УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ  
ТӨМӨР ЗАМЫН ДЭЭД СУРГУУЛЬ**

16050 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,  
Энхтайваны өргөн чөлөө 44, Утас: 24 22 60, Факс: 24 22 70,  
И-мэйл: rail-inst@ubtz.mn

2022.10.07

№

47/359

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Эрдэм шинжилгээ, онол практикийн хурал  
зохион байгуулах тухай

“Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн үйл ажиллагаанд менежментийн тогтолцооны олон улсын стандартуудыг нэвтрүүлэн хэрэгжүүлэх, нийгэмлэгийн бүтээгдэхүүн үйлчилгээний чанар бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2022 оныг “Менежментийн нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан “Төмөр замын салбар дахь менежментийн нэгдсэн тогтолцоо” сэдэвт эрдэм шинжилгээ, онол практикийн хурлыг 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр зохион байгуулахаар төлөвлөж байна.

Захиалагч, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг байнга нэмэгдүүлэх, ХАБЭА болон байгаль орчны эрсдэлийг хянах, удирдах, тасралтгүй сайжруулах, менежментийн тогтолцоонд шинэ инноваци нэвтрүүлэх чиглэлээр салбарын судлаачид, менежер, ажилтнууд харилцан туршлагаа хуваалцах, бие биенээсээ суралцах боломжийг бүрдүүлэх зорилгоор уг хурлыг зохион байгуулж байгаа тул та бүхэн өөрийн байгууллагын ажилтнуудаа идэвхитэй хамруулан оролцуулан дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төмөр замын дээд сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга М.Бямбасүрэн /утас 21242267, 99183426/-ээс авна уу

Хурлын удирдамжийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 2 хуудастай

ЗАХИРАЛ



У.МЯГМАРСҮРЭН /Ph.D/

1647220198

“УБТЗ” ХНН-ийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн ..... дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**“ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАР ДАХЬ МЕНЕЖМЕНТИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦОО” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ОНОЛ ПРАКТИКИЙН ХУРЛЫН УДИРДАМЖ**

**НЭГ. ЗОРИЛГО:** “Менежментийн нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэх жил” зорилтын хүрээнд менежментийн нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэхэд тулгамдсан асуудал түүнийг шийдвэрлэсэн сайн туршлага, санаачилгыг сурталчлах, харилцан туршлага солилцоход оршино.

**ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ:** “УБТЗ” ХНН-ийн бүх бүтцийн нэгж (бүтцийн нэгж гэдэгт алба, хэлтэс, төв, тасаг, салбар нэгжүүдийг ойлгоно.), төмөр замын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд, их, дээд сургуулийн эрдэмтэн, судлаачид болон ахисан түвшний оюутнууд

**ГУРАВ. СЭДВИЙН ЧИГЛЭЛ:**

- ✓ Төмөр замын салбарт олон улсын стандартуудыг нэвтрүүлэх асуудал
- ✓ Менежментийн нэгдсэн тогтолцоо (МНТ)-г хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдэл
- ✓ МНТ-г хэрэгжүүлсэн тухай үр дүнтэй сайн жишээ (аж ахуйн нэгж байгууллагын бодит жишээ, тулгардаг бэрхшээлүүд, шийдвэрлэж болох арга зам, туршлага сургамжийг тусгах)
- ✓ Чанарын менежментийн онол, арга зүйн асуудлууд
- ✓ Гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоо
- ✓ Аж ахуйн нэгж, байгууллагад МНТ-ны соёл төлөвшүүлэх асуудлууд
- ✓ Чанарын менежмент нь байгууллагын менежментийн тогтолцооны бусад асуудлуудтай хэрхэн уялдах тухай (стандарт, шаардлага гэх мэт)
- ✓ МНТ-г нэвтрүүлсэн олон улсын туршлага, сургамж, чанарын бодлогын чиг хандлагын өнөөгийн байдал

**ДӨРӨВ. ХУГАЦАА:**

- ✓ Судлаачийн оролцох хүсэлт (Оролцогч нь овог нэр, байгууллага, албан тушаал, илтгэлийн нэр, холбогдох утасны дугаар гэсэн мэдээллүүдийг)-ийг 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 20.00 цаг хүртэл [rail-inst@ubtz.mn](mailto:rail-inst@ubtz.mn) хаягаар хүлээж авна.
- ✓ Эрдэм шинжилгээний өгүүллийг 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 20.00 цаг хүртэл [rail-inst@ubtz.mn](mailto:rail-inst@ubtz.mn) хаягаар хүлээж авна. Бүтээлийн эхийг Microsoft Word (\*.docx) файл хэлбэрээр илгээнэ.
- ✓ I шатны шалгаруулалтын дүнг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр зарлаж, оролцогчдод урилга, хөтөлбөр илгээнэ.
- ✓ Шалгарсан шилдэг 9 илтгэл, уригдсан 3 илтгэл аман хэлбэрээр, бусад илтгэлүүд ханан илтгэлээр 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр хэлэлцүүлэгдэнэ. Ханан илтгэлээс шилдэг 2 илтгэлийг шалгаруулна. Хэвлэлийн шаардлага хангасан илтгэлүүдийг хэвлэн олны хүртээл болгоно.

#### **ТАВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛД ТАВИХ ШААРДЛАГА:**

1. Илтгэлийн нэр, зохиогч, албан газрын нэрийг эхэнд бичнэ.
2. Илтгэл нь хураангуй, түлхүүр үг, оршил, сэдэв сонгосон үндэслэл, үндсэн хэсэг(текст, зураг, хүснэгт) дүгнэлт, ашигласан материал, талархал(бичихгүй байж болно.), зохиогчийн товч намтрыг оролцуулан А-4 хэмжээгээр 5-8 хуудсанд багтсан байна.
3. Илтгэлийг Times New Roman фонтоор 11 pt үсгийн өндрийг сонгож, хуудасны дээд, баруун, зүүн талаас нь 2.5 см, доод талаас нь 3.0 см, мөр хоорондох зай 1 sp байна. Header, Footer, Footnote команд ашиглахгүй, хуудас дугаарлахгүй.
4. Илтгэлийн хураангуйг 15 мөр, 200 үгэнд багтаан бичнэ. Илтгэлд 4-5 түлхүүр үг хэрэглэгдэх ба түлхүүр үг нь нэр үг, нэрлэхийн тийн ялгал, ганц тоо байна. Илтгэлийн нэрэнд орсон үг түлхүүр үгэнд орохгүй.
5. Илтгэлд оруулсан фото зураг, зураг, график нь хар цагаан өнгөтэй, математик бичиглэлүүд Equation программаар мөр голлон бичигдэнэ. Томьёоны дугаарыг тухайн мөрний төгсгөлд бага хаалтад бичнэ.
6. Илтгэлийн төгсгөлд тухайн илтгэлийг бичсэн хүний товч намтрыг 8 мөр, 80 үгэнд багтаан, Times New Roman фонтоор 10 pt үсгийн өндөртэй бичнэ. Үүнд: Зохиогчийн овог нэр, төгссөн сургууль, холбогдох утас,

#### **ЗУРГАА. ИЛТГЭЛИЙГ ШАЛГАРУУЛАХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД:**

1. Зарласан сэдвийн аль нэгийг сонгосон байх;
2. Сонгосон сэдвийн хүрээнд бодит нөхцөл байдал, дэвшүүлж буй шийдлийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байх;
3. Олон улсын чиг хандлагатай уялдсан, шинэлэг санаа дэвшүүлсэн байх;
4. Илтгэл нь эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах ерөнхий шаардлагыг хангасан хураангуй, удиртгал, үндсэн хэсэг, дүгнэлт, иш татсан ном зохиол, бүтээл, судалгаа, эх сурвалжийг тодорхой дурдсан байх;
5. Илтгэл нь зохиогчийн эрхийг зөрчөөгүй байх.
6. Ашигласан материал бичсэн байх

#### **ТАВ. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:**

Уригдсан илтгэл-3: Өргөмжлөл, тус бүр 300 мянган төгрөг  
Шилдэг илтгэл-9: Өргөмжлөл, тус бүр 300 мянган төгрөг  
Ханан илтгэл-2 Өргөмжлөл, тус бүр 200 мянган төгрөг